

# АЙМГИЙН ТӨСВИЙН ТОДОТГОЛЫН ТАНИЛЦУУЛГА

## 1. МОНГОЛ УЛСЫН 2022 ОНЫ ТӨСӨВТ ХИЙСЭН ТОДОТГОЛЫН ТАЛААР

УИХ-ын чуулганы 2022 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар, Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн буюу төсвийн тодотголын төслүүдийг эцэслэн баталлаа.

Энэ удаагийн төсвийн тодотгол гадаад нөхцөл байдлаас шалтгаалан өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ ханшийн өсөлттэй байгаа энэ хүнд цаг үед иргэдийнхээ бодит орлогыг хамгаалахад чиглэж байна. Үүнд:

Дэлхийн нийтийг хамарсан Коронавируст халдварын цар тахлаас шалтгаалан үүссэн эдийн засгийн хүндрэлийн үед төсвийн бүх шатны байгууллагууд 2021 онд Засгийн газрын 43 дугаар, 2022 оны Засгийн газрын 388 дугаар тогтоолыг тус тус мөрдөн ажиллаж урсгал зардлыг бууруулж ажилласан ч БНХАУ-ын Засгийн газрын “Тэг-КОВИД”-ын бодлогын улмаас хилийн боомтын нөхцөл байдал чангарсан, түүнчлэн ОХУ-ын Украйны нөхцөл байдлаас шалтгаалан дэлхийн зах зээлд түүхий эдийн үнэ өссөний улмаас хэрэглээний үнийн өсөлт нэмэгдэж 2022 оны 03 дугаар сарын байдлаар Монгол Улсын инфляцийн түвшин 14.4 хувьд хүрээд байгаа нь төсвийн зарлагыг нэмж бууруулах зайлшгүй шаардлага бий болсноор дараах 3 арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөлөө.

- 1. Төрийн хэмнэлтийн бодлого:** “Төрийн хэмнэлтийн тухай” хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлж баталлаа.
  - Төрийн тусгай албан хаагчаас бусад төрийн албан хаагч дүрэмт хувцас хэрэглэхийг хориглоно.
  - Төрийн жинхэнэ болон төрийн үйлчилгээний албан хаагч, төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн албан хаагчийн албан тушаалын автомашины ашиглалтыг хязгаарлана.
  - Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй автомашины ашиглалтад хяналт тавина.
  - Төрийн жинхэнэ болон төрийн үйлчилгээний албан хаагч, төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн албан хаагч албан томилолтоор нислэг үйлдэх бол зөвхөн энгийн зэрэглэлээр үндэсний агаарын тээврийг сонгож үйлчлүүлнэ.
  - Бүх шатны албан хаагчийн ажиллах орчин, техник хэрэгслийн нийтлэг жишгийг шинэчлэн батлуулна.
  - Захиргааны зориулалттай барилга байгууламж шинээр барихгүй.
  - Төрийн албан хаагчийн гар утас, шатахууны төлбөр зэрэг бусад хангамжийн зардлыг төсвөөс санхүүжүүлэхгүй.
  - Төрийн тусгай чиг үүрэг хэрэгжүүлдэг агентлаг, Улсын Их Хуралд ажилаа шууд хариуцан тайлагнадаг байгууллага дэд, орлогч даргатай байна.

- Төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
  - Төсөвт байгууллагыг хэмнэлтийн горимд үргэжлүүлэн ажиллуулна.  
Дээрх бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор төсөвт байгууллагын зарим зардал, арга хэмжээг бүрэн болон хэсэгчлэн зогсоох замаар төсвийн жил дуустал **39.1 тэрбум** төгрөг хэмнэхээр тооцсон байна.
- 2. Цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх бодлого.**
- 3. Иргэдийн орлого, ажлын байрыг хамгаалах, амжиргааг дэмжих, нийгмийн баталгааг сайжруулах бодлогын хүрээнд:**
- Нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн зарим даатгуулагчийн шимтгэлийн 50 хувийг буцаан олгох эрх зүйн зохицуулалтыг бий болгоно.
  - Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 2022 оныг дуустал 100 мянган төгрөгөөр бэлнээр үргэжлүүлэн олгоно.
  - Импортын хүнсний ногоог орлох дотоодын үйлдвэрлэлийг дэмжинэ.
  - Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулна.
  - Нийтлэг үйлчилгээний төрийн албан хаагчийн цалинг 1 шатлалтай болгох зэрэг болно.

## **2. АЙМГИЙН 2022 ОНЫ ТӨСӨВТ ТОДОТГОЛ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, БАРИМТАЛСАН ЗАРЧИМ**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, Улсын Их Хурлаас 2022 оны улсын төсөвт тодотгол хийсэнтэй холбогдуулан Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1, 60 дугаар зүйлийн 60.2.4, 64 дүгээр зүйлийн 64.1.2 дахь заалт, мөн “Орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зарлагыг төсөвт тусган баталж хэрэгжүүлэх ба зарлага нь санхүүжүүлэх эх үүсвэрээсээ хэтрэхгүй байна” гэсэн Төсвийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.3 дахь заалтыг зэргийг үндэслэл болгон энэхүү тодотголын тооцоолол, тогтоолын төслийг боловсруулсан болно.

Улсын Их Хурлаас баталсан төсвийн тодотголтой холбогдуулан аймгийн төсөвт тодотгол хийгдэж байгаа бөгөөд Сангийн яамнаас өгсөн чиглэл, тооцооллыг үндэслэхийн зэрэгцээ дараах зарчмуудыг баримталлаа.

- Бүх шатны төсөвт байгууллагуудын урсгал зардлыг бууруулав. Ингэхдээ төрийн албан хаагчийн орлогод шууд нөлөөлөх болон төрийн үйлчилгээний чанарыг бууруулах үр дагавартай цалин хөлс болон эрүүл мэндийн зардлыг бууруулалгүйгээр зөвхөн төсөв байгууллагуудын хувьсах зардал буюу хангамж, бараа материал, норматив, эд хогшил, урсгал завсар, томиллолт, зочны зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний болон бараа үйлчилгээний бусад зардлуудыг тус тус бууруулав.
- 2022 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөр тасалбар болгон орон нутаг дахь ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, политехник коллеж, театр, музей, номын сан, сумын соёлын төв, эрүүл мэнд зэрэг байгууллагын

- байрны үйлчилгээний чиг үүргийг хэрэгжүүлдэг төрийн үйлчилгээний ТҮ1-ТҮ3 зэрэглэлийн албан хаагчдын цалин хөлс Улсын төсөвт шилжсэн тул гүйцэтгэл, өр авлагыг харгалзан батлагдсан төсвийг бууруулах.
- Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолоор санхүүжилтийн хагас бие даасан тогтолцоонд шилжсэн салбарууд болох боловсрол, эрүүл мэнд, соёл, шинжлэх ухаанн салбарын үйлчилгээний албан хаагчдийн цалингийн доод хэмжээг тогтоосон. Харин төрийн захиргааны байгууллагын үйлчилгээний албан хаагчдийн цалингийн шатлалыг Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 192, мөн аймаг, сумдын төрийн захиргааны зарим албан хаагчийн албан тушаалын ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалтад өөрчлөлт оруулах тухай Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 194 дүгээр тогтоолууд гарч тэдгээр албан хаагчдийн цалин урамшуулал тодорхой хэмжээнд нэмэгдсэн. Үүнтэй холбогдуулан аймаг, сумдын Засаг даргын Тамгын газрын цалингийн санг, батлагдсан ирсэн төсвийн хэмжээнд нэмэгдүүлэх тооцооллыг хийж төсөв хуваарилах.
  - Аймгийн ерөнхий орлогын данс, орон нутгийн хөгжлийн сангийн дансны 2021 оны жилийн эцсийн үлдэгдэл, төвлөрүүлсэн бусад орлогоор 2022 оны төсөвт дутагдалтай байгаа зардлын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, эх үүсвэрийн дутагдалтай байгаа, өр үүссэн урсгал зардал, орон нутгийн хөгжлийн сан, хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээг санхүүжүүлэх, шаардлагагүй арга хэмжээг өөрчлөх, хасах .
  - “Хөгжсөн-Хөвсгөл 2030” хөтөлбөр болон 2021-2024 онд хэрэгжүүлэх аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан төлөвлөхийг тус тус үндсэн зарчмаа болгон ажиллалаа.

### **3. АЙМГИЙН ТӨСӨВТ ХИЙГДЭХ ӨӨРЧЛӨЛТ:**

**-Улсын Их хурлаас баталсан тодотголын хүрээнд орон нутгийн төсөвт орох өөрчлөлтийн талаар:**

Улсын Их Хурлаар батлагдсан 2022 оны төсвийн тодотголоор аймгийн нийт тусламж, дэмжлэгийн орлого 30,571.7 сая төгрөг байхаар батлагдаж ирсэн нь оны эхний батлагдсан дүнгээс 6,139.1 сая төгрөг буюу 16.7 хувиар буурсан. Үүнд: Улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг 21,748.7 сая төгрөгөөр баталж ирүүлсэн нь анх батлагдсан дүнгээс 5,388.7 сая төгрөг буюу 19.7 хувиар, орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгийг оны эхэнд батлагдсан 9,623.3 сая төгрөгөөс 800.4 сая төгрөг буюу 8.3 хувиар тус тус бууруулж баталсан байна.

Санхүүгийн дэмжлэгээр буурсан 5,388.7 сая төгрөг нь сумдын эмнэлэг, ерөнхий боловсрол, сургуулийн өмнөх боловсрол, биеийн тамир спорт, мэргэжлийн боловсролын байгууллагуудын Нийтлэг үйлчилгээний зардал буюу үйлчилгээний албан хаагчдийн (ТҮ1-3) цалин, хөлс болон нэмэгдэл, урамшуулал, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал нь 2022 оны 05 дугаар сарын 01-нээс улсын төсвөөс санхүүжихээр болсонтой холбоотой бууралт, мөн орон нутгийн болон сумдын бүх шатны төсөвт байгууллагуудын хувьсах болон урсгал шилжүүлгийн зардлыг 6,0%-иар хасч тодотгосны бууралт болно.

Боловсрол, эрүүл мэндийн салбарын үйлчилгээний албан хаагчдийн цалингаас хасагдсан зардлыг тооцохдоо Сангийн яамнаас өгсөн чиглэлийн дагуу 2022 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөр тасалбар болгон 05 дугаар сарын 30-ны өдрөөрх гүйцэтгэл, 04 дүгээр сарын өглөгийн мэдээг үндэслэн аймгийн болон сумын дээрх байгууллагуудын төсөв, холбогдох зардлыг нийт 4,663.1 сая төгрөгөөр бууруулсан бол орон нутгийн төсөвт байгууллагуудын хувьсах зардлыг 30.1 сая төгрөгөөр бууруулан тооцсон.

Аймгийн болон сумын Засаг даргын Тамгын газрын үйлчилгээний албан хаагчдийн цалингийн шатлалыг тухайн зэрэглэлийн хамгийн дээд түвшин буюу 5 дугаар шатлалд шилжүүлж ахиулахаар шийдвэрлэсэн, мөн төрийн захиргааны зарим албан хаагчдын цалин нэмэгдсэнтэй холбогдуулан батлагдаж ирсэн 257.4 сая төгрөгийг холбогдох байгууллагуудын төсөвт нэмэгдүүлж хуваарилсан.

2022 оны орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг анх 9,623.3 сая төгрөг баталснаас тодотголоор 800.4 сая төгрөгөөр буурч 8,823.0 сая төгрөгөөр батлагдсан. Энэ бууралт нь итгэлцүүрийн олгох санхүүжилтаас буурсан бөгөөд журмын дагуу хуваарилалт хийхэд 400.2 сая төгрөг буюу 50 хувь нь аймгийн орон нутгийн хөгжлийн санд, 400.2 сая төгрөг буюу 50 хувь нь сумдын орон нутгийн хөгжлийн сангаас буурч байна.

#### **-2021 оны давсан орлого, дансны үлдэгдэл, 2022 оны орон нутгийн орлогыг тодотгох талаар.**

Аймгийн ерөнхий орлогын дансны 2021 оны жилийн эцсийн үлдэгдэл **806.2 сая** төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн дансны үлдэгдэл **931.9** сая төгрөг, аймгийн 2021 оны давсан орлого 1,279.7 сая төгрөг, Төсвийн тухай хуулийн дагуу доод шатны төсвөөс төвлөрүүлэх **260.4 сая** төгрөг, 2022 оны аймгийн 4 нэр төрлийн орлогыг **756.0 сая** төгрөгөөр нэмэгдүүлж, УИХ-аас баталсан тодотгол, гүйцэтгэлийн зөрүүгээс үүссэн эх үүсвэрийг **686.8** сая төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого /аймгийн Засаг даргын Тамгын газар/ 19,5 сая төгрөг, нийт **4,740.5** сая төгрөгөөр 2022 оны аймгийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэн тодотгохоор төлөвлөлөө. Үүнийг задалж тайлбарлавал:

Аймгийн ерөнхий орлогын дансны 2021 оны жилийн эцсийн үлдэгдэл **806.2** сая төгрөг нь дараах эх үүсвэрээс бүрдсэн. Үүнд:

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын үлдэгдэл 223,2 сая төгрөг, авто замын сангийн дансны үлдэгдэл 157,9 сая төгрөг, хөрөнгө оруулалтын дансны үлдэгдэл 185,8 сая төгрөг, аймгийн ЗДТГ-ын данснаас төвлөрүүлсэн үлдэгдэл 107,4 сая төгрөг, бусад дансны төвлөрүүлэлт 131,9 сая төгрөг.

Аймгийн 2021 оны давсан орлого 1,779.7 сая төгрөгнөөс 500,0 сая төгрөгийг 2022 оны анхны төсөв батлахад зардлын эх үүсвэр болгон баталсан тул үлдэгдэл 1,279.7 сая төгрөгнөөс 1,193.1 сая төгрөг нь хөрөнгө оруулалтын болон урсгал зардалд, 86,6 сая төгрөг нь авто, тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын давалт тул хуулийн дагуу авто замын сангийн эх үүсвэр болгон тодотголд оруулсан.

“Төсвийн тухай” хуулийн 56 дугаар зүйлийн 56.2.1 заалтын дагуу доод шатны төсвөөс төвлөрүүлэх **260.4 сая** төгрөгийг дараах байдлаар тооцсон болно.

-2021 онд 24 сумын давсан орлого 3,233.7 сая төгрөг үүнээс 2,471.7 сая төгрөгийг хасч тооцсон: Үүнд:

- Самрын орлого /Галт сум/-80,0 сая төгрөг
- Мал бүхий иргэдийн орлогын татварын давсан дүн 820,2 сая төгрөг
- 2022 оны төсвийн эх үүсвэр болгон баталсан дүн 1,571.5 сая төгрөг

Давсан орлого 3,233.7 сая төгрөгөөс дээрх 2,471.7 сая төгрөгийг хасч үлдэгдэл 868,0 сая төгрөгний 30 хувь болох 260,4 сая төгрөгийг 19 сумаас аймагт татан төвлөрүүлэхээр тооцож тогтоолын төслийн 6 заалтад тусгасан. Галт, Жаргалант, Их-Уул, Төмөрбулаг, Цэцэрлэг сумд /малын хөлийн татвараас бусад/ давсан орлогоо бүрэн баталсан тул аймагт төвлөрүүлэх орлого байхгүй болно.

-2022 оны аймгийн орлогыг 756,0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн. Үүнд: Үйлдвэрлэлийн зориулалттай ус ашигласны төлбөрийн орлого 15,0 сая төгрөг /Хатгал сумаас төвлөрүүлнэ/, ногдол ашиг 223,0 сая төгрөг /Могойн гол ХК-ий 2021 оны ногдол ашиг/, түрээсийн орлого 18,0 сая төгрөг /Хөдөөгийн шийдэл ХХК-ий хүлэмж, арьс шир боловсруулах тоног төхөөрөмжийн түрээс/, Орон нутгийн өмчийн хөрөнгө борлуулсны 500.0 сая төгрөг /Эмийн эргэлтийн санг дуудлага худалдаагаар борлуулсны орлогоос/.

- УИХ-аас баталсан тодотгол, гүйцэтгэлийн зөрүүгээс үүссэн **686.8** сая төгрөгийг орлогын эх үүсвэр болгон тогтоолд тусгасан.

-Аймгийн Засаг даргын Тамгын газар туслах үйл ажиллагааны орлогоос 2,5 сая төгрөг, архивын лавлагааны орлогоос 17,0 сая төгрөг нийт 19,5 сая төгрөгийн орлогыг төсөвт байгууллагын өөрийн орлогоос бүрдүүлэхээр төлөвлөсөн.

Орон нутгийн төсвийн эх үүсвэр 4,740.5 сая төгрөг төлөвлөснөөс орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрт 1,110.6 сая төгрөг буюу 24,2 хувь, орон нутгийн хөрөнгө оруулалтын зардлын эх үүсвэрт 1,735.3 сая төгрөг буюу 36,6 хувь, замын сангийн эх үүсвэрт 244,5 сая төгрөг буюу 5,2 хувь, орон нутгийн төсөвт байгууллагуудын урсгал зардалд 1,388.0 сая төгрөг буюу 29,3 хувь, байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардалд 223,2 сая төгрөг буюу 4,7 хувийг тус тус хуваарилсан байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрт хуваарилагдсан 1,110.6 сая төгрөгний 651,5 сая төгрөг нь шилжих хөрөнгө оруулалт, 459,1 сая төгрөг нь шинээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд хуваарилагдсан.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын зардлын эх үүсвэрт хуваарилагдсан 1,735.3 сая төгрөгний 251,5 сая төгрөг нь шилжих хөрөнгө оруулалт, 1,483.8 сая төгрөг нь шинээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд хуваарилагдсан байна.

Замын сангийн эх үүсвэрт 244,5 сая төгрөгний 100,0 сая төгрөг нь шилжих хөрөнгө оруулалт, 144,5 сая төгрөг нь шинээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд хуваарилагдсан.

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардалд хуваарилагдсан 223,2 сая төгрөгний 8,606.3 сая төгрөг нь шилжин хэрэгжих арга хэмжээнд, 214,6 сая төгрөг нь шинээр хэрэгжүүлэх арга хэмжээнд төлөвлөгдсөн.

2022 оны орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг анх 9,623.3 сая төгрөг баталснаас тодотголоор 800.4 сая төгрөгөөр буурч 8,823.0 сая төгрөгөөр батлагдсан. Энэ бууралт нь итгэлцүүрийн олгох санхүүжилтаас буурсан бөгөөд

журмын дагуу хуваарилалт хийхэд 400.2 сая төгрөг буюу 50 хувь нь аймгийн орон нутгийн хөгжлийн санд, 400.2 сая төгрөг буюу 50 хувь нь сумдын орон нутгийн хөгжлийн сангаас буурч байна. Сумдын орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгийг хүн ам, газар нутгийн хэмжээ, алслалтын байдлыг харгалзан батлагдсан аргачлалын дагуу хуваарилсан. Сүүлийн жилүүдэд тавигдсан дэд бүтэцтэй холбоотой аймаг сумын хооронд явах маршрутад өөрчлөлт орж, аймаг сум хүртэлх зайн километр өөрчлөлт орсоныг /аймгийн Автотээврийн төвийн даргын баталсан аймгийн төсвөөс сумын төв хүртэлх зай/ орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгийг хуваарилах алслалтын зайн итгэлцүүрт оруулан тооцсон болно.

#### **4. ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

Тогтоолын төслийн 1-5 дугаар заалтад Улсын Их хурлаас баталсан тогтоолын дагуу өөрчлөлт орж байгаа татаас, дэмжлэгүүдийн дүн болон сум, байгууллагуудад хуваарилагдсан, өөрчлөлт орсон төсвийн дүнгүүдийг тусгасан.

Тогтоолын 6 дугаар заалтад Төсвийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2.1 дэх заалтын дагуу сумдаас дээд шатны төсөвт төвлөрүүлэх мөнгөн дүнгийн жагсаалтыг баталж байна.

Тогтоолын 7 дугаар заалтад аймгийн ерөнхий орлогын дансны 2021 оны жилийн эцсийн үлдэгдэл, доод шатны төсвөөс төвлөрүүлэх хөрөнгө, аймгийн төсвийг нэмэгдүүлэх эх үүсвэрүүдийг тусгасан бол 8 дугаар заалтад тогтоолын хавсралтууд буюу аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөнөөс хасагдах заалтууд, орон нутгийн хөрөнгө оруулалт, аймгийн авто замын сан, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хэрэгжүүлэх арга хэмжээнүүд, төсвийн урсгал зардлаар хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалт болон төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн үзүүлэлт, сумын төсвийн байгууллагуудын төсөвт орсон өөрчлөлт, худалдан авах ажиллагааны шинэчилсэн төлөвлөгөө зэргийг батлах тухай заалтуудыг тусгасан.

9 дүгээр заалтаар Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн ээлжит IX хуралдааны 05 дугаар тогтоолын 04 дүгээр хавсралтаар батлагдсан “Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2022 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт”-д орсон өөрчлөлт, 10 дугаар заалтаар “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар 2022 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд оруулах өөрчлөлтийг оруулсан бол 11-15 дугаар заалтуудад төсөвт тодотгол хийж байгаатай холбогдуулан цаашид анхаарах асуудлуудыг тодорхойлон бүх шатны төсөв захирагч нарт даалгасан, үүрэг болгосон заалтуудыг тусгасан болно.

#### **АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭС, ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТЭС**